



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР**

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН
ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН.**

**Сүхбаатар сум
2017 оны 4 дүгээр сар**

Тайланг бэлтгэсэн:

Сэлэнгэ аймгийн Аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор:

Ч.Энхтуяа

Аудитын менежер:

Б.Батмөнх

Ахлах аудитор:

С.Бат-Эрдэнэ

Б.Наранчимэг

Аудитор:

Б.Эрдэнэзул

Ц.Отгонбаяр

Шинжээч:

С.Баасансүрэн

Ц.Уртнасан

А.Дашбат

Э.Эрдэнэзул

Ж.Цогт

Уг тайланг УАГ-ын

Цахим хуудаснаас үзнэ үү:

www.audit.mn

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7036-3040, 7036-3047, 7036-2442, 7036-3036 дугаарын утас, 7036-3040 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:

ТАБ-ын хаяг: УАГ-ын харьяа Сэлэнгэ аймгийн Аудитын газар
Байршил: АЗДТГ-ын байрны өргөтгөлд

Товчилсон үгийн жагсаалт.....3
Нэг. Ерөнхий зүйл

Аудит хийсэн үндэслэл, хугацаа.....4
Аудитын зорилт, хамарсан хүрээ.....4
Аудитын арга зүй.....4-5
Орон нутгийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал.....5

Хоёр. Санхүүгийн дотоод хяналт6-7

Гурав. Шилэн дансны мэдээлэл.....7-9

Дөрөв. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

4.1. Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар.....10
4.2 Мөнгөн хөрөнгийн дансанд илэрсэн алдаа зөрчлийн талаар.....10-11

Тав. Авлагын бүртгэл, тайлагнал

5.1. Авлагын бүтэц, бүрэлдэхүүний талаар.....11-12
5.2. Авлагын дансанд илэрсэн алдаа зөрчлийн талаар....12-12

Зургаа. Бараа материалын бүртгэл, тайлагнал

6.1. Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар.....12-13
6.2 Бараа материалын дансанд илэрсэн алдаа зөрчлийн талаар.....13-13

Долоо. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

7.1. Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүний талаар.....13-14
7.2 Үндсэн хөрөнгийн дансанд илэрсэн алдаа, зөрчлийн талаар..... 14-15

Найм. Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

8.1. Өр төлбөрийн бүтцийн талаар.....15-16
8.2.Өр төлбөр дансанд илэрсэн алдаа, зөрчлийн талаар 16-16

Ес. Орлогын бүртгэл, тайлагнал

9.1. Орлогын бүтэц, бүрэлдэхүүний талаар.....16-18
9.2.Орлогын дансанд илэрсэн алдаа, зөрчлийн талаар....18-19

Арав. Зардлын бүртгэл, тайлагнал

10.1. Зардлын бүтэц, бүрэлдэхүүний талаар.....19
10.1.1 Аймгийн нийт төсвийн зарлагын талаар19-20
10.1.2 Орон нутгийн төсвийн зарлагын талаар20-21
10.1.3 Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлагын талаар21
10.2. Зардлын дансанд илэрсэн алдаа22

10.2.1 Цалингийн зардлын гүйцэтгэлтэй холбоотой алдаа, зөрчлийн талаар.....	22-23
10.2.2 Бусад зардлын гүйцэтгэлтэй холбоотой алдаа, зөрчлийн талаар.....	23-24
10.2.3 НДШ, ХХОАТ, НӨАТ-ын бүртгэл тайлагналтай холбоотой алдаа, зөрчлийн талаар.....	24
10.2.4 Орон нутгийн хөрөнгө оруулалттай холбоотой алдаа, зөрчлийн талаар.....	24-25
10.2.5 Замын сан, хөрөнгө оруулалтын барьцааны дансны талаар.....	25-25
10.2.6 Орон нутгийн хөгжлийн сангийн талаар.....	25-26

Арван нэг. Төсөл, сангийн бүртгэл тайлагнал	26-26
11.1.Төсөл, сангийн дансанд илэрсэн алдаа, зөрчлийн талаар.....	26-27
Арван хоёр. Аймаг, сумын орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудиын дүнгийн талаар.....	27
Арван гурав. Улсын төсвөөс олгох тусгай шилжүүлгээр санхүүжих төсвийн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар.....	27-28
Арван дөрөв. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар	28-29
Арван тав. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар;	29
Арван зургаа. Анхаарал татахуйц бусад чухал асуудал..	29-30
Арван долоо. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд...	30-31
Арван найм. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	31
Арван ес. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, тайлант онд өгсөн зөвлөмж.....	31
Хорь. Аудитын санал дүгнэлт.....	31-32

Хавсралтууд:

- 1.Менежментийн захидал
- 2.Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 3.Аудитаар илэрсэн зөрчлийн дэлгэрэнгүй хавсралтууд
- 4.Албан шаардлага

Товчилсон үгийн жагсаалт

АТӨЯХАТ	Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга, хот байгуулалтын сайд
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ЖДҮДС	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТЭДТДҮТ	Тариалан эрхлэлтийг дэмжих, техник дундын үйлчилгээний төв
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХАА	Хөдөө аж ахуйн
ХАСХОМ	Хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлэг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан

Нэг. Ерөнхий зүйл

Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4, Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн аудитын тухай хуулийн 15.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн /ТЕЗ/ төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд СЭЛ/2017/01-СТА-ТЕЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд хийхээр төлөвлөн Сэлэнгэ аймгийн Аудитын газрын ахлах аудитор С.Бат-Эрдэнэ, Б.Наранчимэг, Аудитор Б.Эрдэнэзул, Ц.Отгонбаяр, шинжээч С.Баасансүрэн, А.Дашбат, Ц.Уртнасан, Э.Эрдэнэзул, Ж.Цогт нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон бусад шаардлагын дагуу бэлтгэж, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль, тогтоомжийн хүрээнд хийгдэн, үнэн шударга илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаагаар дээд шатны төсвийн захирагч болон хэрэглэгчдийг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангууд иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг тэдгээр тайланд хавсаргах ёстой. Эдгээр мэдээллийг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах нь аудитын зорилт бөгөөд хамарсан асуудлууд болно.

Сэлэнгэ аймгийн Аудитын газар аймгийн ТЕЗ-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, санал дүгнэлт гаргахын өмнө Төсвийн тухай болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу орон нутгийн төсвийн төвлөрүүлэн, төсвийн шууд захирагчдын 2016 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

Аудитын арга зүй

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн

тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, хяналтын сорил, шинжилгээний горим болон нарийвчилсан сорил хийж, ихээхэн дүнтэй ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, санхүүгийн тайлан, түүний тодруулгад үнэлгээ өгөв. Ингэхдээ санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг үндсэн шалгуур болголоо.

Орон нутгийн 2016 оны санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал.

Сэлэнгэ аймгийн Засаг дарга Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэх заалтын дагуу Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг нэгтгэж бэлтгэн, хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ УСНББОУС -д заасан зарчим, Сангийн сайдын 2016 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг баримтлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1, 6.1 дэх заалтуудын дагуу нягтлан бодох бүртгэлийн тохируулсан аккрузл суурийг хэрэглэж, Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлсэн байна.

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд:

- *Аймаг, сумдын 18 төрийн сан;*
- *Орон нутгийн төсвийн 104, улсын төсвийн тусгай шилжүүлгийн 131, нийт 235 байгууллага, 31 төсөл сан;*
- *Орон нутгийн өмчит 13 үйлдвэрийн газар зэрэг нийт 297 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.*

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дараах бүрэлдэхүүнтэй байна.

А. Үндсэн тайлан:	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн байдлын тайлан	НББ-ийн бодлого, зарчим
Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн үр дүнгийн тайлан	Толилуулгын суурь
Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх мөнгөн гүйлгээний тайлан	
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	

Дээрх тайлангуудыг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу санхүүгийн байдлын, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлангуудыг “Санхүүгийн тооцоолох” ХХК-ийн “Plastic” програм болон Сангийн яамны **“е-тайлан”**-д нэгтгэн бүртгэж, санхүүгийн тайлан бэлтгэх

аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна. Тус програм нь нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт, заавар, журамтай нийцсэн байна

Хоёр. Санхүүгийн дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед их гэж тооцсон бөгөөд дахин хянахад дотоод хяналтын эрсдэл их байна. Энэ талаар дурдвал:

Төсвийн тухай хуулийн 69-р зүйлийн 69.1-д *“Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэгдсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна”* гэж заасны дагуу аймгийн Засаг даргын 2014 оны 11-р сарын 25-ны өдрийн А/433 дугаар захирамжаар дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх “Санхүүгийн хяналт, аудитын алба” –ыг аймгийн Засаг даргын дэргэд байгуулж, албаны дүрмийг баталсан байна.

Аймгийн Аудитын газрын сүүлийн жилүүдэд хийсэн аудитиудаас харахад аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн дотоод хяналтын үр нөлөө хангалтгүй, тайлан, дүгнэлт бодит байдалтай нийцэхгүй байдал ажиглагдаж байгаа бөгөөд их хэмжээний хөрөнгө мөнгөний эргэлт явагддаг, зарцуулалтын эрсдэл ихтэй төсөл, хөтөлбөрүүдийг хяналт, шалгалтад хамруулалгүйгээр, эрсдэл багатай төр, төсвийн жижиг байгууллагуудыг ээлжлэн шалгаснаар хяналт, шалгалт зорилгоо хангаж чадахгүй байх зэрэг байдлууд ажиглагдаж байна.

Тухайлбал, зарцуулалтын эрсдэл ихтэй улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, аймаг, сум хөгжүүлэх сан, орон нутгийн хөгжлийн сан зэрэг төсөл, хөтөлбөрүүдийг шалгалтад огт хамруулахгүй байгаа бөгөөд 2016 оны 10 сард Сүхбаатар сумын бүрэн дунд сургуулиудын санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн шалгалтын дүн, тайланг өнөөг хүртэл хүргүүлээгүй байна.

Их хэмжээний өр төлбөр, авлага хуримтлагдсан, жил ирэх бүр алдагдын хэмжээ нэмэгдсэн, бие даан үйл ажиллагаа явуулах чадвар алдагдсан орон нутгийн өмчит томоохон аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж бүгдэд нь *“зөрчил илрээгүй, хэвийн байна”* гэж дүгнэлт өгсөн нь бодит байдалтай нийцэхгүй байгаа талаар аймгийн Аудитын газраас 2016 онд хийж гүйцэтгэсэн *“Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны үр дүн”* сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланд дурдаж байсан билээ.

Аймгийн Аудитын газар нь аливаа аудитыг эрсдэлд суурилан төлөвлөж, гүйцэтгэдэг учир ТЕЗ-ийн санхүүгийн дотоод аудитын үйл ажиллагаатай холбоотой дээрх эрсдэлтэй асуудлуудад үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15-р зүйлийн 15.2 дахь *“Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага дараах бүрэн эрх эдэлнэ”, 15.2.1 дэх “Орон нутгийн захиргааны болон төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд аудит хийх”* гэсэн заалт болон олон улсын Аудитын дээд байгууллагуудаас гаргасан аудитын үндсэн зарчмуудын тунхаглалд *“Аудитын дээд байгууллага нь /төрийн аудит / хөндлөнгийн аудитор болохын хувьд дотоод аудитын үр нөлөөг шалгах үүрэгтэй”* гэсэн зарчим, ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн тайлангийн явцын аудитын хүрээнд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны үйл ажиллагаанд аудит хийхээр төлөвлөн аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг хүргүүлсэн боловч тус албаны дарга Б.Дарихжавын гарын үсгээр баталгаажсан, 2016 оны 12 сарын 27-ны өдрийн 145 дугаар албан бичгээр *“Тус санхүүгийн хяналт, аудитын алба нь чиг үүрэг адил хяналтын байгууллага учир санхүүгийн хяналт шалгалт, аудитын*

тайлан, танилцуулгыг шалгуулахаар хүргүүлэхгүй болохыг мэдэгдэе” гэсэн хариу ирүүлсэн байна.

Энэ нь тус алба нь хяналт, шалгалтыг холбогдох хууль, стандарт, дүрэм, журмын дагуу төлөвлөж, гүйцэтгэдэггүй, тайлан, дүнг дор бүр нь холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлдэггүй, шалгалтаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авдаггүй, шалгалтын материалыг дүрэмд заасны дагуу үдэж цэгцэлж, архивын нэгж болгон хадгалдаггүй, өөрөөр хэлбэл төрийн аудитын байгууллагад үзүүлж, шалгуулах баримт, материал байхгүй гэж үзэхэд хүргэж байна.

Нөгөө талаас, уг үйлдэл нь Төрийн аудитын тухай хуулийн 21-р зүйлийн 21.1 дэх “*Төрийн аудитын байгууллага, түүний ажилтнууд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах аливаа мэдээллийг бүрэн хэмжээгээр, чөлөөтэй, шуурхай авах эрхтэй. Энэ хуулийн 15.1-д заасан байгууллага, албан тушаалтан төрийн аудитын байгууллагаас шаардсан мэдээллийг хугацаанд нь саадгүй гаргаж өгөх үүрэгтэй*” гэсэн заалтыг зөрчиж байгаа тул тус хуулийн 28-р зүйлийн 28.1 дэх “*Төрийн аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, аудит хийлгэхээс зайлсхийсэн, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан..... албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ*” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлж байна.

Цаашид аймгийн ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албаны үйл ажиллагаа, хяналт шалгалтын үнэн зөв, үр нөлөөт байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, тус байгууллагын үйл ажиллагааг холбогдох хууль, стандарт, дүрэм, журамд нийцүүлэх, дотоод хяналт шалгалтын үр өгөөж, үр нөлөөг сайжруулах арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй юм.

Харин аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн Төрийн сангийн дотоод аудитын нэгжээс 2016 онд 9 сум, тосгоны төрийн сангийн үйл ажиллагаа болон аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт дотоод хяналт хийж гүйцэтгэсэн байна. Нийт төрийн сангийн 41 хувьд нь хяналт хийн, 130 зөвлөмж өгч биелэлтийг тооцож ажилласан байна.

Дотоод хяналтыг санхүүжилт болон тайлагналтын хяналтын, төлбөр тооцооны, системийн хяналтын, төрийн сангийн дотоод үйл ажиллагааны хяналтын, төсөвт байгууллагуудад хийсэн хяналтын гэсэн 5 үндсэн чиглэлээр хийж гүйцэтгэсэн байна.

Санхүүгийн хяналт, аудитын албатай хамтран Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна. Уг ажлын хүрээнд сумдын Санхүүгийн албаны дарга, мэргэжилтэн нарт 2 удаагийн сургалт зохион байгуулж, сар бүр бүх төсөвт байгууллагуудын зарлагын дэлгэрэнгүй тайланг Санхүүгийн хяналт, аудитын албанд хүргүүлж, хуулийн хэрэгжилт, мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавих нөхцлийг бүрдүүлсэн байна.

.Гурав. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу явуулахаас гадна салбарын хэмжээнд хяналт тавьж ажиллахаар заасан.

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн төсвийн багцад харьяалагддаг Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд хамаарах төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд 183 байгууллага, аймаг, сумдын 18 ТЕЗ, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг үзүүлдэг 44 байгууллага зэрэг нийт 245 хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байна.

Сэлэнгэ аймгийн орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6.1 дэх заалт, Засгийн газрын 2016 оны

01-р сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу www.shilendans.gov.mn хуудсанд шаардлагатай мэдээллийг тавьж ажиллаж байна.

Үндэсний аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-ийг шалгаж, 2016 оны 11 сар хүртэлх хугацааг хамруулан нийцлийн аудит хийж гүйцэтгэсэн.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар нийт **4,985.1** сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. *5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалттай холбоотой мэдээллийг оруулаагүй нийт 1,506.3 сая төгрөгийн. Үүнд:*
 - *14 сумын орон нутгийн төсвийн болон ТЗШ-ийн 50 байгууллага 1,198.9 сая төгрөгийн,*
 - *5 ОНӨААТҮГ, 14 удаагийн 307.4 сая төгрөгийн.*
2. Цалингийн зардлаас бусад 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээг мэдээлээгүй 1,559.4 сая төгрөгийн. Үүнд:
 - *14 сумын, орон нутгийн төсвийн болон ТЗШ-ийн 50 байгууллага 110 удаагийн 1,511.2 сая төгрөгийн,*
 - *4 ОНӨААТҮГ, 5 удаагийн 48.2 сая төгрөгийн зарлагын гүйлгээг,*
3. 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээг мэдээлээгүй 377.5 сая төгрөгийн. Үүнд:
 - *Орон нутгийн төсвийн болон ТЗШ-ийн 7 байгууллага 10 удаагийн 204.4 сая төгрөгийн,*
 - *5 ОНӨААТҮГ, 14 удаагийн 173.1 сая төгрөгийн орлогын гүйлгээг,*
4. Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн талаар мэдээлээгүй 1,178.2 сая төгрөгийн. Үүнд:
 - *Орон нутгийн төсвийн болон ТЗШ-ийн 60 байгууллага, 310 удаагийн 1,149.5 сая төгрөгийн,*
 - *4 ОНӨААТҮГ, 24 удаагийн, 28.7 сая төгрөгийн орлогын гүйлгээг,*
5. Өр төлбөр, авлага дутуу мэдээлсэн 20.0 сая төгрөгийн. Үүнд:
 - *1 ОНӨААТҮГ 20.0 сая төгрөгийн өглөгийг тус тус мэдээлээгүй.*
6. *Сэлэнгэ аймагт төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль, тогтоомж, гэрээний үндсэн дээр хийж гүйцэтгэгч 35 байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс нээлгээгүйгээс 343.7 сая төгрөгийн санхүүжилтийг мэдээлээгүй,*
7. *Тухайн жилийн төсвийг 01-р сарын 10-ны өдрийн дотор мэдээлэхээс 5 ОНӨААТҮГ мэдээлээгүй,*
8. *Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жил бүрийн 01-р сарын 10-ны өдрийн дотор мэдээлэхээс орон нутгийн болон ТЗШ-ийн 171 байгууллага, 9 ОНӨААТҮГ зэрэг нийт 180 хуулийн этгээд мэдээлээгүй,*
9. *Дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор мэдээлэхээс орон нутгийн болон ТЗШ-ийн 98 байгууллага, 10 ОНӨААТҮГ зэрэг нийт 108 хуулийн этгээд мэдээлээгүй,*
10. *2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор мэдээлэхээс орон нутгийн болон ТЗШ-ийн 25 байгууллага, 5 ОНӨААТҮГ зэрэг нийт 30 хуулийн этгээд мэдээлээгүй,*
11. *2016 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор мэдээлэхээс орон нутгийн болон ТЗШ-ийн 40 байгууллага, 6 ОНӨААТҮГ зэрэг нийт 46 хуулийн этгээд мэдээлээгүй,*
12. *Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор мэдээлэхээс орон нутгийн болон ТЗШ-ийн 39 байгууллага, 5 ОНӨААТҮГ зэрэг нийт 43 хуулийн этгээд мэдээлээгүй,*

13. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор мэдээлэхээс орон нутгийн болон ТЗШ-ийн 102 байгууллага, 10 ОНӨААТҮГ зэрэг нийт 122 хуулийн этгээд мэдээлээгүй,
14. Төсвийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарыг улирал бүр мэдээлэхээс орон нутгийн болон ТЗШ-ийн 72 байгууллага, 9 ОНӨААТҮГ зэрэг нийт 81 хуулийн этгээд мэдээлээгүй,
15. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг орон нутгийн болон ТЗШ-ийн 38 байгууллага, 2 ОНӨААТҮГ зэрэг нийт 40 хуулийн этгээд мэдээлээгүй,
16. Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг орон нутгийн болон ТЗШ-ийн 36 байгууллага, 1 ОНӨААТҮГ зэрэг нийт 37 хуулийн этгээд мэдээлээгүй,
17. Худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнгийн талаарх мэдээллийг орон нутгийн болон ТЗШ-ийн 85 байгууллага, 6 ОНӨААТҮГ зэрэг нийт 91 хуулийн этгээд мэдээлээгүй,
18. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг орон нутгийн болон ТЗШ-ийн 36 байгууллага, 1 ОНӨААТҮГ зэрэг нийт 37 хуулийн этгээд мэдээлээгүй,
19. "Сэлэнгэ үржлийн цөм сүрэг" ОНӨААТҮГ нь шилэн дансны цахим хуусанд 2016 оны эхний 3 улирлын байдлаар мэдээлвэл зохих мэдээллийг огт оруулаагүй байна.
20. 12 сумын төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлтийг мэдээлээгүй зэрэг зөрчил илэрсэн байна.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд үндэслэн дараах дүгнэлтүүдийг өгсөн байна.

1. Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн 99,6 хувь нь нийт мэдээлвэл зохих мэдээллийн 80,9 хувийг мэдээлсэн байна./ Сэлэнгэ үржлийн цөм сүрэг" ОНӨААТҮГ- аас бусад /
2. Аймгийн ТЕЗ-ийн харьяа 201 байгууллага шилэн дансанд мэдээлвэл зохих мэдээллийн 76,4 хувийг байршуулсан байна.
3. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүд шилэн дансны бие даасан цэс нээлгээгүй, холбогдох мэдээллийг байршуулаагүй байна.
4. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль, тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэж буй хуулийн этгээдийн 27,7 хувь нь шилэн дансанд цэс нээлгээгүй бөгөөд мэдээлвэл зохих мэдээллийн 44,7 хувийг мэдээлээгүй байна.
5. Аймгийн ИТХ-ын зүгээс холбогдох байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийгдэхгүй байна.
6. Аймгийн ТЕЗ-ийн зүгээс шилэн дансны үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналтаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж, дүгнэхгүй байна.

Цаашид аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа хуулийн этгээдүүдийн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим санд бүрэн байршуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийж буй дотоод хяналтын үр дүнг үнэлэх, өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тухай бүр тооцож байх талаар анхаарч ажиллах нь зүйтэй байна.

Дөрөв. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд дараах зүйлсийг бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

- Төрийн сангийн нэгдсэн данс дахь аймаг, сумдын төрийн сангийн дансны үлдэгдэл;
- ОНӨААТҮГ-уудын арилжааны банкинд байршдаг харилцах дансдын үлдэгдэл болон зарим төсвийн байгууллагын жижиг мөнгөн сангийн үлдэгдэл;
- Кассанд байгаа бэлэн мөнгө.

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2015 оны эцэст 3,305.4 сая төгрөг байснаас 45.7 хувиар өсч 4,815.2 сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд үүний 90.6 хувь буюу 4,365.2 сая төгрөг нь төрийн сангийн бүртгэлийн дансанд байршиж байна.

4.1 Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар

хүснэгт-1

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл /2015.12.31/	Эцсийн үлдэгдэл /2016.12.31 /	Кассанд байгаа бэлэн мөнгө	Банкинд байгаа бэлэн мөнгө	
				Арилжаан ы банк	Төрийн сангийн нэгдсэн данс
Кассад байгаа бэлэн мөнгө	14.8	32.1	32.1		
Банкинд байгаа бэлэн мөнгө	3,290.6	4,783.1	-		
Төрийн сангийн харилцах	2,882.5	4,365.2			4,365.2
Нэмэлт санхүүжилтийн харилцах	86.4	-			-
Арилжааны банкин дахь харилцах	321.7	417.9		417.9	
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	3,305.4	4,815.2	32.1	417.9	4,365.2
Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:					
Төрийн сан	2,114.59	2,890.1		0.2	2,889.9
Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага	0.01	0.2		0.2	0.00
Орон нутгийн төсөвт байгууллага	443.08	543.9	0	0.6	543.3
ОН-ийн өмчит үйлдвэрийн газар	328.90	449.0	32.1	416.9	
Төсөл, сангууд	418.82	932.00			932.00
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	3,305.4	4,815.2	32.1	417.9	4,365.2

Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 60 хувийг төрийн сангийн, 19.3 хувийг төсөл, сангийн, 9.3 хувийг ОНӨААТҮГ-ын, 11.4 хувийг төсөвт байгууллагуудын мөнгөн хөрөнгө эзэлж байна.

4.2 Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгийн данстай холбоотой гарсан зөрчлийн талаар

Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн түвшинд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгийн данстай холбоотой нийт 518.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 377.1 сая төгрөгийн алдааг залруулж, 46.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 94.2 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмжийг хүргүүлсэн байна. /Алдаа, зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт № 1-т үзүүлэв /

Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэлд тусгасан, ажил, гүйлгээг шууд зардлаар бүртгэсэн, кассын тайлан гаргаагүй, холбогдох журналын бичилтийг буруу бүртгэсэн, төсөв захиран зарцуулах

эрхгүй албан тушаалтан төсөв, хөрөнгө захиран зарцуулсан зэрэг алдаа, зөрчлүүд нийтлэг байдлаар илэрсэн байна. Тухайлбал;

- Анхан шатны баримтын бүрдэл дутуу нийт 50.8 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан,
- Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 3 дахь заалтуудыг зөрчин 345.9 сая төгрөгийн ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулж бүртгэлгүйгээр мөнгөн хөрөнгийн данснаас шууд зардалд бүртгэсэн,
- Мөнгөн хараа чуулгын дарга нь сумын ИТХ-ын сонгуульд нэр дэвшихтэй холбоотойгоор аймгийн Засаг даргын 2016 оны Б/52 захирамжаар захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийг туслах найруулагчид хариуцуулсан байхад бүжгийн багш Б.Гоцбаяр төсөв захирагчийн үүргийг гүйцэтгэн, 38.8 сая төгрөгийн төсөв захиран зарцуулсан байна.

Тав.Авлагын бүртгэл, тайлагнал

5.1 Авлагын бүтэц, бүрэлдэхүүний талаар

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын оны эхний үлдэгдэл 14,544.3 сая төгрөг байснаас тайлант онд 194.4 сая төгрөг буюу 1.3 хувиар буурч, оны эцэст 14,349.9 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Нийт авлагын үлдэгдлийг бүтцээр нь харуулбал:

хүснэгт -2

(сая төгрөгөөр)

Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл /2015.12.31/	Эцсийн үлдэгдэл /2016.12.31/	Өсөлт /+ / бууралт -/	Дүнд эзлэх хувь
Нийт дүн	14,544.3	14,349.9	(194.4)	100.0
Ажиллагчидтай холбогдсон авлага	42.4	22.0	(20.3)	0.2
Төлбөртэй ийлчилгээний авлага	2.0	0.1	(2.0)	0.0
Татаас, санхүүжилтийн авлага	511.2	256.7	(254.5)	1.8
Зээлийн хүүгийн авлага	62.4	199.9	137.5	1.4
Дансны авлага /ТӨҮГ/	958.5	1,246.9	288.4	8.7
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	3.9	104.7	100.8	0.7
Байгууллагаас авах авлага	1,980.9	2,253.2	272.4	15.7
Хувь хүмүүсээс авах авлага	9,959.8	4,412.9	(5,546.8)	30.8
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	1,023.2	1,021.4	(1.8)	7.1
Хувь хүмүүст олгосон зээл		4,831.9	4,831.9	33.7
Байгууллагын төрлөөр				
Төрийн сан	1,092.3	1,060.4	(31.87)	7.4
Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага	61.7	85.1	23.43	0.6
Орон нутгийн төсөвт байгууллага	134.1	370.7	236.59	2.6
Төсөл сан	10,502.9	9,448.3	(1,054.59)	65.8
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	2,753.3	3,385.3	632.01	23.6
Нийт өр төлбөрийн дүн	14,544.3	14,349.9	(194.43)	100.0

Хүснэгтээс үзэхэд нийт авлагын 65.8 хувийг төсөл, сангийн, 23.6 хувийг ОНӨААТҮГ-ын, 7.4 хувийг төрийн сангийн, 3.2 хувийг төсөвт байгууллагын авлага тус тус эзэлж байна.

Төрийн сангийн авлагын дүнд 2000 оноос өмнө үүссэн, хариуцах эзэн нь тодорхой бус 277.1 сая төгрөгийн, аймгийн төсвөөс “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-т олгосон 744.5 сая төгрөгийн зэрэг нийт 1,021.5 сая төгрөгийн авлагын үлдэгдэл тайлагнагдаж байна.

5.2 Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар авлагын данстай холбоотой гарсан зөрчлийн талаар

Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн түвшинд хийсэн аудитаар авлагын данстай холбоотой нийт 72.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч аудитын явцад 15.6 сая төгрөгийн алдааг залруулж, 1.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 55.2 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмжийг хүргүүлсэн байна. /Алдаа зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт № 2-т үзүүлэв./

Аудитаар санхүүгийн тайланд авлагын үлдэгдлийг илүү, дутуу тайлагнасан, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, төсвийг зохистой удирдаагүйгээс жилийн эцэст авлага үүсгэсэн зэрэг алдаа, зөрчил нийтлэг илэрсэн байна. Тухайлбал;

- Санхүүгийн тайланд 17.5 сая төгрөгийн авлага дутуу тусгагдсан,
- Төсвийг зохистой удирдаагүйгээс Түнхэл тосгоны цэцэрлэг 1.0 сая төгрөгийн, Сайхан сумын соёлын ордон, спорт клубууд 0.9 сая төгрөгийн, аймгийн ЗДТГ 0.3 сая төгрөгийн зэрэг нийт 2.3 сая төгрөгийн авлага шинээр үүсгэсэн,
- Орхонтуул сумын 1-р сургууль 1.5 сая төгрөгийн, Сүхбаатар сумын ТҮГ 9.1 сая төгрөгийн, “Сэлэнгэ зүүнхараа” ОНӨААТҮГ 4.8 сая төгрөгийн зэрэг нийт 15.4 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.

Зургаа.Бараа материалын бүртгэл, тайлагнал

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт бараа материалын эхний үлдэгдэл 4,981.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 6,040.5 сая төгрөгөөр тайлагнагдаж, тайлант онд 1,058.8 сая төгрөгөөр өссөн байна.

6.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар

хүснэгт-3

(сая төгрөгөөр)

Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл /2015.12.31/	Эцсийн үлдэгдэл /2016.12.31/	Өсөлт /+ / бууралт -/	Дүнд эзлэх хувь
Нийт дүн	4,981.7	6,040.5	1,058.8	100.0
Түүхий эд материал	1,144.2	1,593.9	449.7	26.4
Тусгай зориулалттай материал	364.7	525.7	161.0	33.0
Эм боох материал	59.9	134.9	75.0	8.5
Дуусаагүй үйлдвэрлэл	6.8	-	(6.8)	-
Бэлэн битээгдэхийн	712.8	933.3	220.5	58.6
Хангамжийн материал	3,794.8	4,401.9	607.1	72.9
Бичиг хэргийн материал	85.5	109.1	23.6	2.5
Аж ахуйн материал	1,905.4	2,240.3	334.9	50.9
Сэлбэг хэрэгсэл	476.7	527.2	50.6	12.0
Түлш, шатах тослох материал	46.7	61.7	15.0	1.4

Барилгын засварын материал	20.2	31.1	10.9	0.7
Хүнсний материал	42.0	105.5	63.4	2.4
Бусад хангамжийн материал	1,157.4	1,265.1	107.7	28.7
Мал амьтад	60.9	61.9	1.0	1.4
НӨӨЦИЙН БАРАА	42.7	44.7	2.0	0.7
Бусад нөөц	42.6	44.7	2.1	100.0
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	0.1	-	(0.1)	-
Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:				
Төрийн сан	0	0	0	0
Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага	2,988.1	3,512.1	524.0	58.1
Орон нутгийн төсөвт байгууллага	556.0	687.2	131.2	11.4
Төсөл сан	59.0	47.3	(11.7)	0,8
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	1,378.6	1,793.9	415.3	29.7
Нийт бараа материалын дүн	4981.7	6040.5	1,058.8	100.00

6.2 Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар бараа материалын данстай холбоотой гарсан зөрчлийн талаар.

Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн түвшинд хийсэн аудитаар бараа материалын данстай холбоотой нийт 931.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 660.1 сая төгрөгийн алдааг залруулж, 32.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 5.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 233.9 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмжийг хүргүүлсэн байна. /Алдаа зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт № 3-т үзүүлэв./

Аудитаар тайлант жилийн төсвийн хэмнэлтээр бараа материал худалдан авч нөөцөлсөн, санхүүгийн тайланд материалын үлдэгдлийг зөрүүтэй тусгасан, бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгө бүртгэсэн, худалдан авсан бараа материалыг орлого аваагүй зэрэг алдаа, зөрчил нийтлэг илэрсэн байна. Тухайлбал;

- 14 байгууллага бараа материалын дансанд 133.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж, чанартай хөрөнгийг бүртгэсэн,
- Орхон сумын сургууль түлш, халаалтын зардлын хэмнэлт болох 11.9 сая төгрөгөөр дараа онд хэрэглэх түлээ, нүүрс, Хушаат сумын сургууль хүүхдийн хоолны зардлын хэмнэлтээс 7,6 сая төгрөгийн, цэцэрлэг 7.1 сая төгрөгийн хүнсний материал худалдан авч нөөцөлсөн байна.
- 24 байгууллага худалдан авсан 87.6 сая төгрөгийн бараа материалыг материалын тайланд орлогоор бүртгээгүй байна.

Долоо.Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 197,976.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 217,522.9 сая төгрөгөөр тайлагнагдаж, тайлант онд 19,546.2 сая төгрөгөөр өссөн байна.

7.1 Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүний талаар

хүснэгт-4

(сая төгрөгөөр)

Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл /2015.12.31/	Эцсийн үлдэгдэл /2016.12.31/	Өсөлт /+ / бууралт -/	Дүнд эзлэх хувь
Нийт хөрөнгийн дүн	197,976.7	217,522.9	19,546.2	100.0
Биет хөрөнгө	197,171.8	216,695.8	19,524.0	99.6
Барилга, байгууламж, орон сууц	148,653.1	166,132.1	17,479.0	76.4
Авто-тээврийн хэрэгсэл	6,273.5	6,471.7	198.2	3.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	14,388.3	14,991.3	603.0	6.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	6,095.2	6,358.1	262.9	2.9
Зам, гүүрийн байгууламж	4,147.8	4,373.9	226.1	2.0
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	2,026.7	2,026.7	-	0.9
Бусад үндсэн хөрөнгө	11,086.7	12,100.7	1,014.0	5.6
Дуусаагүй барилга, байгууламж	3,581.4	3,285.7	(295.7)	1.5
Ном	919.1	955.6	36.5	0.4
Биет бус хөрөнгө	804.9	827.1	22.2	0.4
Програм хангамж	117.5	139.7	22.2	0.1
Бусад биет бус хөрөнгө	687.4	687.4	-	0.3
Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:				
Төрийн сан	0	0	0	0
Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага	120,323.8	133,383.7	13,059.9	61.3
Орон нутгийн төсөвт байгууллага	41,831.3	48,253.6	6,422.3	22.2
Төсөл сан	4.9	3.9	(1.0)	0.0
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	35,816.7	35,881.7	65.0	16.5
Нийт үндсэн хөрөнгийн дүн	197,976.7	217,522.9	19,546.2	100.0

Хүснэгтээс үзэхэд нийт үндсэн хөрөнгийн 61.3 хувийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын, 22.2 хувийг орон нутгийн төсвийн байгууллагын, 16.5 хувийг орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөрөнгө эзэлж байна. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 9.9 хувиар буюу 19,546.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

7.2 Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгийн данстай холбоотой гарсан зөрчлийн талаар

Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн түвшинд хийсэн аудитаар үндсэн хөрөнгийн данстай холбоотой нийт 1,413.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 829.2 сая төгрөгийн алдааг залруулж, 198.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 386.0 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмжийг хүргүүлсэн байна. / Алдаа зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт № 4-т үзүүлэв./

Аудитаар санхүүгийн тайланд хөрөнгийн үлдэгдлийг зөрүүтэй тусгасан, худалдан авсан болон үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлогыг дутуу бүртгэсэн, холбогдох журналын бичилтүүдийг буруу бүртгэсэн, байгууллагын хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн барилга, байгууламж, тээврийн хэрэгслүүд улсын бүртгэлд хувь хүний эзэмшилд бүртгэгдсэн зэрэг алдаа, зөрчил нийтлэг байдлаар илэрсэн байна. Тухайлбал;

- Алтанбулаг сумын 2-р цэцэрлэгийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 167.1 сая төгрөгийн дансны үнэ бүхий цэцэрлэгийн барилгаа нь улсын бүртгэлд эрхлэгч Ж.Мөнхтуяагийн нэр дээр бүртгэгдсэн,
- ГХБХБГ-ын дансанд бүртгэлтэй 15.5 сая төгрөгийн, Сүхбаатар сумын өрхийн ЭМТ-ийн дансанд бүртгэлтэй 9.0 сая төгрөгийн, “Урсгал ус” ХХК-ийн дансанд бүртгэлтэй 30.0 сая төгрөгийн, “Сэлэнгэ зүүнхараа” ОНӨААТҮГ-ийн дансанд бүртгэлтэй 30 сая

төгрөгийн дансны үнэ бүхий автомашинуудын тээврийн хэрэгслийн гэрчилгээ нь хувь хүний нэр дээр бүртгэлтэй байна.

- Тайлант онд худалдан авсан болон, үнэ төлбөргүй хүлээн авсан нийт 145.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого авч, санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Найм.Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

Сэлэнгэ аймгийн ТЭЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өглөгийн эхний үлдэгдэл 8,658.4 сая төгрөг байснаас тайлант онд 5.8 хувиар буюу 508.0 сая төгрөгөөр өсч, оны эцэст 9,166.4 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

8.1 Өр төлбөрийн бүтэц, бүрэлдэхүүний талаар

хүснэгт-5

(сая төгрөгөөр)

Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл /2015.12.31/	Эцсийн үлдэгдэл /2016.12.31/	Өсөлт /+ / бууралт -/	Дүнд эзлэх хувь
НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,658.4	9,166.4	508.0	100.0
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,658.4	9,166.4	508.0	100.0
Богино хугацаат зээлийн өглөг	1,952.3	1,788.2	(164.1)	19.5
Өглөг	6,704.0	7,345.1	641.1	80.1
Ажилчидтай холбогдсон өглөг	180.5	18.4	(162.1)	0.2
Бараа үйлчилгээний зардлын өглөг	216.0	33.7	(182.3)	0.4
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	73.6	233.5	159.9	2.5
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	0.2	220.0	219.8	2.4
Байгууллагад төлөх өглөг	1,792.4	729.9	(1,062.5)	7.9
Хувь хүмүүст төлөх өглөг	69.1	5.4	(63.7)	0.1
Татварын өр /ТӨҮГ/	898.7	1,379.5	480.8	15.1
НДШ-ийн өр /ТӨҮГ/	984.6	1,166.3	181.7	12.7
Ноогдол ашгийн өр /ТӨҮГ/	2.0	2.0	-	0.0
Дансны өглөг /ТӨҮГ/	2,486.9	3,556.4	1,069.5	38.8
Урьдчилж орсон орлого	2.0	33.1	31.1	0.4
Бусад урьдчилж орсон орлого	2.0	33.1	31.1	0.4
Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:				
Төрийн сан	623.2	418.0	(205.2)	4.5
Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага	853.3	28.5	(824.8)	0.3
Орон нутгийн төсөвт байгууллага	170.1	306.2	136.1	3.3
Төсөл сан	548.4	359.8	(188.6)	3.9
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	6,463.4	8,053.9	1,590.5	88.0
Нийт өр төлбөрийн дүн	8,658.4	9,166.4	508.0	100

Нийт өр төлбөрийн 4.5 хувийг төрийн сангийн, 0.3 хувийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын, 3.3 хувийг орон нутгийн төсөвт байгууллагын, 3.9 хувийг төсөл сангийн, 88.0 хувийг ОНӨААТҮГ-уудын өр төлбөр эзэлж байна.

8.2 Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өр төлбөрийн данстай холбоотой гарсан зөрчлийн талаар

Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн түвшинд хийсэн аудитаар өглөгийн данстай холбоотой нийт 1,708.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 38.2 сая төгрөгийн алдааг залруулж, 0.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1.670.1 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмжийг хүргүүлсэн байна. / Алдаа, зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт № 5-т үзүүлэв./

Аудитаар төсвийг зохистой удирдаагүйгээс өглөг үүсгэсэн, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, санхүүгийн байдлын тайланд зөрүүтэй илэрхийлсэн, урьд онд үүссэн боловч тайланд үлдэгдлээр тусгаагүй өглөгийг тайлант жилийн зардлаас барагдуулсан зэрэг алдаа, зөрчил нийтлэг илэрсэн байна. Тухайлбал

- Төсвийг зохистой удирдаагүйгээс нийт 46.3 сая төгрөгийн өглөг үүсгэсэн,
- Урьд оны санхүүгийн тайланд үлдэгдлээр тусгаагаагүй 47.0 сая төгрөгийн өглөгийг тайлант оны зардлаас барагдуулсан,
- Санхүүгийн байдлын тайланд нийт 17.9 сая төгрөгийн өглөг илүү, 27.1 сая төгрөгийн өглөг дутуу тайлагнасан байна.

Ес.Орлогын бүртгэл, тайлагнал

9.1 Төсвийн орлого, санхүүжилтийн талаар

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 74 дугаар тогтоолоор аймгийн төсвийн нийт орлогыг 65,075.8 сая төгрөгөөр баталсан бөгөөд тайлант хугацаанд 3 удаа тодотгол хийн, 67,753.4 сая төгрөг болгож, нэмэгдүүлэн баталсан байна.

Аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар Сэлэнгэ аймгийн 2016 оны төсвийн нийт орлогын төлөвлөгөөг жилийн эцэст 69,341.8 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,059.7 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 4,887.3 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт 43,171.6 сая төгрөг, орон нутгийн нийт орлого 18,196.1 сая төгрөг, орон нутгийн болон төсөвт байгууллагуудын өөрийн орлогоос 331.9 сая төгрөг зэрэг нийт 70,646.7 сая төгрөгийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлж, 101.9 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Аймгийн төсвийн нийт орлогын эх үүсвэрийг харуулбал:

хүснэгт -6

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
Орон нутгийн татварын болон татварын бус орлого	14,386.2	16,903.2	18,196.1	1,293.0	107.6
Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	5,325.4	4,059.7	4,059.7	-	100.0
ОНХС-ийн орлогын шилжүүлэг	3,709.7	4,887.3	4,887.3	-	100.0
Тусгай зориулалтын шилжүүлэг	38,574.1	43,171.6	43,171.6	-	100.0
Орон нутгийн төсөвт байгууллагуудын өөрийн орлого	198.7	220.4	242.8	22.4	110.2
ТЗШ –ийн байгууллагуудын өөрийн орлого	82.4	99.6	89.1	(10.5)	89.5
Нийт орлогын эх үүсвэр	62,276.5	69,341.8	70,646.7	1,304.9	101.9

Хүснэгтээс үзэхэд улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлэг, ОНХС-ийн орлогын шилжүүлгийн санхүүжилтүүдийг 100 хувь авч, орон нутгийн орлогын биелэлт 7.6 хувиар давсан бол төсөвт байгууллагуудын өөрийн орлого нийт дүнгээрээ 3.7 хувиар давсан үзүүлэлттэй байна.

9.1.1 Татварын болон татварын бус орлогын талаар

Аймгийн ИТХ-аас аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг анх 1,512.3 сая төгрөгийн татварын буцаан олголтыг хассан дүнгээр буюу 13,853.6 сая төгрөгөөр баталсан бол тайлант онд 3 удаа тодотгол хийж, 1,247.3 сая төгрөгийн татварын буцаан олголтыг хассан дүн болох 12,637.8 сая төгрөгөөр буюу анхны баталсан дүнгээс 1,215.8 сая төгрөгөөр бууруулж баталсан байна. Сумдын ИТХ-аас татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг 4,265.3 сая төгрөгөөр тодотгон баталж, Сэлэнгэ аймгийн урсгал орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 16,903.1 сая төгрөгөөр батлагдсан байна.

Гүйцэтгэлээр аймгийн орлого 18,196.1 сая төгрөгийн, сумдын орлого 5,312.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, нийт дүнгээр 107.6 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Татварын болон татварын бус орлогын гүйцэтгэлийг харуулбал:

хүснэгт -7

(сая төгрөгөөр)

Орлогын нэр төрөл	Өмнөх он	Тайлант оны гүйцэтгэл							
		Аймгийн орлого		Сумдын орлого		Төсвийн нийт орлого			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын болон татварын бус орлого	14,386.2	12,637.8	12,883.5	4,265.3	5,312.6	16,903.1	18,196.1	1,292.9	107.6
Татварын орлого	13,209.2	12,107.8	12,413.1	3,373.5	4,276.4	15,481.3	16,689.5	1,208.2	107.8
Хүн амын орлогын албан татвар	9,006.8	9,451.1	9,796.6	743.3	765.3	10,194.4	10,561.9	367.5	103.6
Өмчийн татвар	796.7	868.3	978.2	0.0	0.0	868.3	978.2	109.9	112.7
Бараа үйлчилгээний албан татвар	3,405.7	1,788.4	1,638.3	2,630.2	3,511.1	4,418.6	5,149.4	730.8	116.5
Татварын бус орлого	1,177.0	530.0	470.4	891.8	1,036.2	1,421.8	1,506.6	84.7	106.0
Өмчийн орлого	7.4			4.3	3.2	4.3	3.0	-1.3	72.9
Торгууль,шимтгэл	651.9	220.0	162.6	525.3	729.6	745.3	892.4	147.1	119.7
Татварын бус бусад орлого	517.7	310.0	307.8	362.2	303.4	672.2	611.2	-61.1	90.9
НИЙТ ОРЛОГЫН ДҮН	14,386.2	12,637.8	12,883.5	4,265.3	5,312.6	16,903.1	18,196.1	1,292.9	107.6

Хүснэгтээс үзэхэд бүлгийн дүнгээр хүн амын орлогын албан татвар 367.5 сая төгрөгөөр, өмчийн татвар 109.9 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний албан татвар 730.8 сая төгрөгөөр татварын бус орлого 84.8 сая төгрөгөөр давж биелэсэн үзүүлэлттэй байна.

Хэдийгээр нийт дүнгээр орлогын төлөвлөгөө давсан боловч 6 сумын орлогын төлөвлөгөө 0.4- 23.2 сая төгрөгийн хооронд буюу нийт 56.9 сая төгрөгөөр тасарсан, 11 сумын орлогын төлөвлөгөө 1.8 сая төгрөгөөс 497.2 сая төгрөгөөр давж биелэсэн байна.

Төсвийн орлогын гүйцэтгэлийг төсвийн захирагчдаар харуулбал

хүснэгт -8

(сая төгрөгөөр)

д/д	Сумдын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Алтанбулаг	371.4	409.2	37.8	110.2
2	Баруунбүрэн	88.8	100.2	11.4	112.9
3	Баянгол	116.3	120.0	3.7	103.2
4	Ерөө	590.7	725.2	134.5	122.8
5	Хүдэр	917.8	1,259.4	341.6	137.2
6	Хушаат	44.9	29.4	(15.5)	65.4
7	Жавхлант	28.6	35.5	6.9	124.4
8	Мандал	889.3	1,386.7	497.4	155.9
9	Орхон	51.7	48.4	(3.3)	93.7
10	Орхонтуул	86.4	73.2	(13.2)	84.7
11	Сайхан	323.7	365.4	41.7	112.9
12	Сант	51.5	50.2	(1.3)	97.5
13	Шаамар	72.8	95.5	22.7	131.2
14	Сүхбаатар	372.1	348.9	(23.2)	93.8
15	Цагааннуур	82.5	84.3	1.8	102.2
16	Түшиг	144.4	149.1	4.7	103.2
17	Зүүнбүрэн	32.4	32.0	(0.4)	98.8
	Сумдын дүн	4,265.3	5,312.6	1,047.3	124.6
18	Аймгийн орлого	12,637.8	12,883.5	245.7	101.9
	Нийт дүн	16,903.1	18,196.1	1,293.00	107.6

Аймгийн орлого нийт дүнгээрээ биелэсэн боловч нэр төрлөөр нь авч үзэхэд улсын тэмдэгтийн хураамж 216.0 сая төгрөгөөр, хүү торгууль, ангилагдаагүй орлого 59.5 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Сумдын орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзэхэд улсын тэмдэгтийн хураамж 61.7 сая төгрөгөөр, бууны албан татвар 6.4 сая төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөр 15.7 сая төгрөгөөр, түрээсийн орлого 1.2 сая төгрөгөөр, хөрөнгийн хөдлөл эрхийн орлого 44.4 сая төгрөгөөр, бусад орлого 1.3 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Орон нутгийн төсөвт байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөө 220.4 сая төгрөгөөр батлагдаж, 242.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөө 99.6 сая төгрөгөөр батлагдаж, 89.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

9.2 Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар орлогын данстай холбоотой гарсан зөрчлийн талаар

Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн түвшинд хийсэн аудитаар орлогын данстай холбоотой нийт 296.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 87.8 сая төгрөгийн алдааг залруулж, 110.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 98.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд аудитын зөвлөмжийг хүргүүлсэн байна. *Алдаа зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт № 6-т үзүүлэв./*

Аудитаар үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд орлого илүү, дутуу тусгасан, төсвийн орлогын төлөвлөгөөг тасалсан, аймгийн төсвийн орлогыг сумын төсөвт төвлөрүүлсэн,

татварын орлогыг касст бэлнээр авч зарцуулсан зэрэг алдаа, зөрчил нийтлэг илэрсэн байна. Тухайлбал;

- Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн 10 байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг нийт 13.9 сая төгрөгөөр тасалсан,
- Орон нутгийн орлогын төлөвлөгөөг Хушаат сум 15.5 сая төгрөгөөр, Орхон сум 3.3 сая төгрөгөөр, Орхонтуул сум 13.2 сая төгрөгөөр, Сант сум 1.3 сая төгрөгөөр, Сүхбаатар сум 23.2 сая төгрөгөөр, Зүүнбүрэн сум 0.4 сая төгрөгөөр зэрэг нийт 56.9 сая төгрөгөөр тасалсан,
- Орхонтуул сум хадлангийн газрын төлбөрийн 16.2 сая төгрөгийн орлогыг аймгийн төсөвт бус сумын төсөвт төвлөрүүлэн зарцуулсан,
- Мандал сум төсвийн орлого болох самрын зөвшөөрлийн хураамж 80.0 сая төгрөгийг /Дархан Сэлэнгэ говь компаниас 40,0 сая төгрөгийн, Буман боргоцой компаниас 40,0 сая төгрөгийн самрын орлого/ ЗДТГ-ын касст бэлнээр авч зарцуулсан байна.

Арав. Зардлын бүртгэл, тайлагнал


10.1 Зардлын бүтэц, бүрэлдэхүүний талаар

10.1.1 Аймгийн төсвийн нийт зарлагын талаар

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 74 дугаар тогтоолоор аймгийн 2016 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээг 65,075.8 сая төгрөгөөр баталсан байна. Анх баталсан төсвийн зарлагыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 80 дугаар тогтоолоор 66,006.2 сая төгрөгөөр, шинээр бүрэлдсэн ИТХ-ын 2016 оны 07 дугаар тогтоолоор 65,504.4 сая төгрөгөөр, 15 дугаар тогтоолоор 67,753.4 сая төгрөгөөр тус тус өөрчилж, 3 удаа тодотгол хийсэн байна.

Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Сэлэнгэ аймгийн 2016 оны төсвийн нийт зардлын төлөвлөгөөг эцсийн байдлаар 77,218.4 сая төгрөгөөр тодотгож баталсан бол төсвийн гүйцэтгэлээр нийт 70,348.0 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төлөвлөгөөнөөс 6,870.4 сая төгрөгөөр бага буюу 91.1 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна. Төсвийн зарлага нийт дүнгээр 8.9 хувиар хэмнэгдсэн нь 2016 онд төсөл, сангийн зардлыг 4,786.3 сая төгрөг буюу 80.1 хувиар хэмнэснээс шалтгаалсан байна.

Төсвийн гүйцэтгэлийг графикаар харуулбал:



Графикаас үзэхэд нийт төсвийн зарлагын 37.4 хувийг орон нутгийн төсвийн байгууллагын, 60.9 хувийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын, 1.7 хувийг төсөл сангийн зарлага эзэлж байна.

10.1.2 Орон нутгийн төсвийн нийт зарлагын талаар:

Орон нутгийн төсвийн 2016 оны нийт зардал 27,971.0 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 26,320.0 сая төгрөг буюу 94.1 хувийн биелэлттэй тайлагнагдсан байна.

Орон нутгийн төсвийн нийт зардлыг хөтөлбөрийн ангилалаар харуулбал.

хүснэгт-9

(сая төгрөгөөр)

Байгууллагын төрөл	2015 оны гүйцэтгэл	2016 оны		зөрүү	хувь
		төлөвлөгөө	гүйцэтгэл		
Аймгийн ИТХ	352.9	392.4	386.7	5.7	98.55
Аймгийн ЗДТГ	2,053.50	1,804.7	1,801.3	3.4	99.81
Ангилалдаагүй бусад зардал	1,693.20	2,053.3	1,856.8	196.5	90.43
Сумын ИТХ	832.1	887.2	816.7	70.5	92.04
Сумын ЗДТГ	4,192.60	6,566.3	6,012.0	554.3	91.56
Багийн засаг дарга	1,433.20	615.8	613.9	1.9	99.70
Хот тохижуулах газар	912.6	754.8	741.7	13.1	98.27
ОНХО	826.9	955.6	738.4	217.2	77.28
ОНХС	3,618.70	5,331.2	4,794.6	536.6	89.93
Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	83.6	121.1	121.1	-	100.00
Орон нутгийн өмчийн газар /Худалдан авах ажиллагааны алба /	101.2	112.2	108.8	3.4	96.95
Байгаль орчин, аялал жуулчлалын газар	460.1	442.2	442.2	0.0	100.00
Халамж, үйлчилгээний хэлтэс	7,441.50	7,788.6	7,755.1	33.5	99.57
Сум дундын ой анги	160.6	145.6	130.7	14.9	89.80
Нийт дүн	24,162.70	27,971.0	26,320.0	1,651.0	94.10

Өмнөх онтой харьцуулахад нийт зардал 15.7 хувиар буюу 2,157.3 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байгаа нь ОНХС-гийн зардал 1,175.9 сая төгрөгөөр, сумдын ЗДТГ болон багийн засаг даргын нийт зардал 1,000.1 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

Орон нутгийн байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн данс оны эхэнд үлдэгдэлгүй байсан бол 1,288.4 сая төгрөгийн орлого төвлөрч, 1,038.7 сая төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулан, 249.7 сая төгрөгийг төвлөрүүлж, оны эцэст харилцахын үлдэгдэлгүйгээр тайлагнагдсан байна.

Нэмэлт санхүүжилтийн нийт зарлагын 85.6 сая төгрөгийг цалин, НДШ-ийн зардалд, 29.6 сая төгрөгийг эд, хогшил худалдан авах урсгал засварын зардалд, 667.1 сая төгрөгийг бусад бараа үйлчилгээний зардалд, 32.8 сая төгрөгийг нэг удаагийн тэтгэмжийн зардалд, 223.6 сая төгрөгийг хөрөнгийн зардалд тус тус зарцуулж, 249.7 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

10.1.3 Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлагын талаар:

2016 онд тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн нийт зарлага 43,271.2 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 42,838.0 сая төгрөг буюу 99,0 хувийн биелэлттэй тайлагнагдсан байна. Төсвийн нийт зарлагын 85 хувийг БСШУС-ын, 13.6 хувийг ЭМС-ын, 0.6 хувийг БХБС-ын, 0.8 хувийг ХНХС-ын багцын байгууллагуудын зарлага эзэлж байна.

Төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөрийн ангилалаар харуулбал.

хүснэгт-10

(сая төгрөгөөр)

Байгууллагын нэр	2015 оны гүйцэтгэл	2016 оны		Зөрүү	хувь
		төлөвлөгөө	гүйцэтгэл		
Сургуулийн өмнөх боловсрол	9,731.3	11,096.7	10,954.4	142.3	98.7
Ерөнхий боловсрол	20,109.4	22,183.6	22,027.7	155.8	99.3
Соёлын үйлчилгээ /соёлын төв /	1,252.2	1,315.4	1,287.7	27.7	97.9
Соёлын үйлчилгээ /соёлын ордон, чуулга /	1,301.9	1,371.0	1,354.6	16.4	98.8
Орон нутгийн музей, номын сан	410.2	411.2	408.0	3.3	99.2
Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	4,574.0	5,537.0	5,479.7	57.3	99.0
Газрын харилцаа, кадастр	239.4	228.6	228.5	0.1	100.0
Хүүхэд хөгжил, хамгааллын үйлчилгээ	289.2	286.3	263.4	22.9	92.0
Нийтийн биеийн тамир	689.5	841.3	834.0	7.3	99.1
Нийт дүн	38,597.1	43,271.2	42,838.0	433.2	99.0

Хүснэгтээс үзэхэд төсвийн зарлага өмнөх оны гүйцэтгэлээс 4,240.9 сая төгрөгөөр буюу 10.9 хувиар өссөн байна.

Нийт төсвийн зарлагын 68 хувийг цалин, шимтгэлийн зардал, 6.9 хувийг нормативт зардал, 5.7 хувийг бусад урсгал шилжүүлгийн зардал, 14.3 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 5.1 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

ТЗШ-ийн байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн харилцахын эхний үлдэгдэл 940 төгрөг байсан бол тайлант онд 1,123.6 сая төгрөгийн орлого төвлөрч, 1,098.4 сая төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулан, 1.5 сая төгрөгийг улсын төсөвт, 23.7 сая төгрөгийг сумдын төрийн санд төвлөрүүлж, жилийн эцэст үлдэгдэлгүйгээр тайлагнагдсан байна.

Нэмэлт санхүүжилтийн нийт зарлагын 20.7 сая төгрөгийг цалин, НДШ-ийн зардалд, эм, хоол худалдан авах зардалд 391.5 сая төгрөгийг, 71.1 сая төгрөгийг эд, хогшил худалдан авах, урсгал засварын зардалд, 444.1 сая төгрөгийг бусад бараа үйлчилгээний зардалд, 171.0 сая төгрөгийг нэг удаагийн болон хөдөө орон нутагт ажилласны тэтгэмжийн зардалд тус тус зарцуулж, 25.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна

10.2 Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар зардлын данстай холбоотой гарсан зөрчлийн талаар

Төсвийн шууд, төвлөрүүлэн болон ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зардлын дансны бүртгэл, тайлагнал, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой нийт 1,790.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, аудитын явцад 385.0 сая төгрөгийн алдааг залруулж, 18.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 675.8 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, 711.4 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмж өгсөн байна./ Алдаа зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт №7-10 -т үзүүлэв./

10.2.1 Цалингийн зардлын гүйцэтгэлтэй холбоотой илэрсэн алдаа, зөрчлийн талаар

ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар цалингийн зардлын гүйцэтгэлтэй холбоотой нийт 227.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 75.1 сая төгрөгийн алдааг залруулж, 11.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 79.0 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, 62.1 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмж хүргүүлэв.

Аудитаар холбогдох хууль, журмыг мөрдөөгүйгээс үндсэн болон цалингийн нэмэгдлийг илүү тооцож олгосон, үндэслэлгүйгээр илүү цалин олгосон, ур чадварын нэмэгдлийг илүү олгосон, батлагдсан орон тоог хэтрүүлсэн, журналын бичилтийг буруу бүртгэсэн зэрэг алдаа, зөрчил нийтлэг илэрсэн байна. Тухайлбал;

- Батлагдсан орон тоог хэтрүүлэн нийт 4.4 сая төгрөгийн цалин, НДШ-ийн зардал гаргасан байна. / Баруунбүрэн сумын сургууль 1.6 сая , Мандал сумын спортын ордон 2.1 сая төгрөгийн, Мөнгөн хараа чуулга 0.7 сая төгрөгийн /
 - Баруунбүрэн сум: Сангийн яамнаас орон тоо, төсвийг нь батлаагүй спорт заалны халаалтын зардлыг аймгийн төсвөөс санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн ч сумын ИТХ-аар уг зардлаас 4 орон тооны цалинг салгаж, ЗДТГ-ын цалингийн сан дээр нэмж тодотгон, нийт 27.6 сая төгрөгийн цалин олгосон,
 - Үндсэн цалинг ЗГ-ын тогтоолоос зөрүүтэй тогтоосноос нийт 5.2 сая төгрөгийн цалинг илүү олгосон,
 - ЕБС-ууд сурагчдын амралттай хугацаанд багш нарт анги даалт, кабинетийн нэмэгдэл, зэргийн нэмэгдлийг олгосноос нийт 2.8 сая төгрөгийн цалинг илүү олгосон,
 - Ээлжийн амралтын цалинг зөрүүтэй тооцоолж, нийт 2.3 сая төгрөгийн цалин илүү олгосон,
 - Үр дүнгийн урамшуулалт цалинг илүү болон давхардуулснаас нийт 40.8 сая төгрөг илүү олгосон.
 - Ур чадварын нэмэгдлийг журмын дагуу ажилтнуудын ажлыг үнэлж , дүгнэлгүйгээр хавтгайруулж болон илүү тооцож, нийт 13.8 сая төгрөг илүү олгосон,
 - Тушаал шийдвэргүй болон хууль эрх зүйн үндэслэлгүйгээр нийт 4.4 сая төгрөгийн цалинг илүү олгосон,
 - Цалингийн журналын бичилтийг буруу бүртгэснээс нийт 62.7 сая төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулалгүйгээр шууд зардлаар бүртгэсэн байна.
- / Зөрчлийн дэлгэрэнгүйг Хавсралт № 7-д үзүүлэв /

10.2.2 Бусад зардлын гүйцэтгэл болон , бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар

ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар бусад зардлын гүйцэтгэлтэй холбоотой нийт 812.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, аудитын явцад 149.3 сая төгрөгийн алдааг залруулж, 7.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 397.2 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, 259.0 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмж хүргүүлэв./ Алдаа, зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт № 8-д үзүүлэв./

А) Холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, зардлыг зориулалт бусаар зарцуулсан, хүүхдийн хоолны нормативт зардлыг мөрдөөгүйгээс хэтрүүлэн зарцуулсан, үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд зардлын гүйцэтгэлийг зөрүүтэй илэрхийлсэн, ажил гүйлгээг шууд зардлаар бүртгэсэн зэрэг нийт 944.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Тухайлбал;

- Зардлын бүлэг хооронд холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр нийт 20.9 сая төгрөгийг гүйлгэн зарцуулсан,

- 3Г-ын 2012 оны 106 дугаар тогтоолоор баталсан зардлын нормативыг мөрдөөгүйгээс дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 11.2 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан, зардлын хэмнэлтээр жилийн эцэст хэрэгцээнээс илүү 7.0 сая төгрөгийн материал худалдан авч нөөцөлсөн байна,
- Аймгийн ИТХ-ын 2016 оны 80-р тогтоолоор баталсан Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын 2.2.19 дахь заалтад “Байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг бууруулах зорилгоор хяналт, шалгалт хийх” ажилд 15.0 сая төгрөг төлөвлөснийг байгууллагын үйл ажиллагааны урсгал зардал болох авто машин засварлахад 14.7 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Худалдан авах ажиллагааны хууль, тогтоомжийг зөрчсөн 147.5 сая төгрөгийн худалдан авалт хийгдсэн байна.

Б) УИХ-ын 2016 оны 09-р сарын 09-ний өдрийн 47 дугаар тогтоолыг зөрчин шинээр үндсэн хөрөнгө худалдан авахад 26.8 сая төгрөгийг, албан ажлын өрөөнд урсгал засвар хийхэд 10.4 сая төгрөгийг, шинэ жилийн арга хэмжээнд 2.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Үүнд:

- Алтанбулаг сумын ЗДТГ сумын Цагдаагийн албанд 14.6 сая төгрөгөөр Toyota Prius маркийн автомашин худалдан авсан,
- Шаамар сумын ЗДТГ нь сумын Цагдаагийн албанд Toyota Prius маркийн автомашин худалдан авахад 5.0 сая төгрөг зарцуулсан,
- Сайхан сумын ЗДТГ 3.4 сая төгрөгийн үнэ бүхий ширээ, сандал худалдан авсан,
- Хушаат сумын ЗДТГ нь 3.8 сая төгрөгөөр тавилга худалдан авсан,
- Ерөө сумын ЗДТГ нь 6.5 сая төгрөгийг, сум дундын Ойн анги нь 0.5 сая төгрөгийн зардлыг урсгал засвар хийхэд зарцуулсан,
- Баянгол сумын ИТХ ажлын албаны конторын хана нураах, засварын ажилд 1.8 сая төгрөгийг зарцуулсан,
- Цагааннуур сумын спорт цогцолбор ажлын байрны урсгал засварт 1.6 сая төгрөгийн зардал гаргасан,

В) Аймаг, сумдын Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтай холбоотой нийт 150.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 8 удаагийн 33.5 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын арга хэмжээнд, 2 удаагийн 8.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,
- Шаамар сум Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас ЗДТГ-ын албан хэрэгцээний автомашинд дугуй авахад 1.2 сая төгрөг, асар майхан худалдан авах 5.2 сая төгрөгийг, ахмадын өргөөнд тавилга эд хогшил худалдан авахад 3.0 сая төгрөгийг зэрэг нийт 9.4 сая төгрөгийг зарцуулсан,
- Хүдэр сум ЗДТГ-ын орон тоонд батлагдаагүй биеийн тамир, спорт хариуцсан мэргэжилтэн, мэдээллийн технологийн ажилтан нарыг гэрээгээр бүтэн жилийн хугацаанд ажиллуулж, Засаг даргын нөөц хөрөнгөөс нийт 7.0 сая төгрөгийн урамшуулал олгосон,
- Цагааннуур сум Засаг даргын нөөц хөрөнгөөс 8 удаагийн арга хэмжээнд зарцуулсан 6.4 сая төгрөгийн гүйцэтгэлийн тайлан гаргаагүй, “Нуурын мэдээ” сонин хэвлүүлж 1.1 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,
- Түшиг сум Засаг даргын захирамжгүйгээр Засаг даргын нөөц хөрөнгөөс цэрэг татлага болон түймрийн зардалд 1.8 сая төгрөгийн зардал гаргасан,
- Мандал сум Засаг даргын нөөц хөрөнгөөс хөрөнгө оруулалтын шинжтэй арга хэмжээнд зарцуулсан, улсын баяр наадмаас харцага цол авсан бөхөд авто машин худалдан авсан, улсын цолтой 11 бөхөд 0.1-1.0 сая төгрөгийг тараасан зэргээр нийт 59.8 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,
- Ерөө сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын цэцэрлэгийн цахилгааны засварт 0.5 сая төгрөгийн, ЕБС-ийн цайны газрын зураг төсвийн үнэнд 4.6 сая төгрөгийн, “Цахим сургууль хөтөлбөр”-ийн зардалд 4.4 сая төгрөгийн, ЭМТ-ийн авто машины

засварт 5.9 сая төгрөгийн, халуун усны халаагчийн үнэнд 0.3 сая төгрөгийн, Бугант тосгоны ЕБС-ийн үдийн цайны байрны засварт 0.9 сая төгрөгийн, цэцэрлэгийн зөөлөн эдлэлийн үнэнд 5.6 сая төгрөгийн зэрэг хөрөнгө оруулалтын шинжтэй, 0.9 сая төгрөгийн шатахууны урсгал зардал зэрэг нийт **23.1** сая төгрөгийн зориулалт бус зардал гаргасан боловч ажил гүйцэтгэх гэрээ, хүлээн авсан комиссын акт, өмч хамгаалах комиссын шийдвэр зэрэг анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй байна.

10.2.3 НДШ, ХХОАТ, НӨАТ-ын бүртгэл тайлагналтай холбоотой гарсан алдаа зөрчил

ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар НӨАТ болон ХХОАТ, НДШ-ийг илүү, дутуу суутгасан, татвар, шимтгэлийн тайланд тайлагнаагүй зэрэг нийт 159.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч аудитын явцад 91.4 сая төгрөгийн алдааг залруулж, 68.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд аудитын зөвлөмж хүргүүлсэн байна. / Алдаа зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт № 9-д үзүүлэв /

10.2.4 Орон нутгийн хөрөнгө оруулалтын талаар

Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 15 дугаар “Сэлэнгэ аймгийн 2016 оны тодотгосон төсөв батлах тухай” тогтоолоор урьд оноос шилжих 7 төсөл, арга хэмжээнд 395.6 сая төгрөг, шинээр эхлэх 29 төсөл арга хэмжээнд 658.7 сая төгрөг, нийт 1,054.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардлыг баталсан байна.

Гүйцэтгэлээр өмнөх оноос шилжиж ирсэн 7 төсөл арга хэмжээний санхүүжилтэд 382.8 сая төгрөгийг, шинээр эхлүүлсэн 14 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 339.0 сая төгрөгийг зарцуулж, аймгийн төрийн санд байрших орон нутгийн хөрөнгө оруулалтын барьцааны дансанд 16.6 сая төгрөгийг шилжүүлэн, төсвийн гүйцэтгэл цэвэр дүнгээр 721.8 сая төгрөгөөр буюу 68.5 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд улсын төсвийн байгууллагуудын урсгал зардал болон хөрөнгө худалдан авахад 23.4 сая төгрөгийг төлөвлөж, 19.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

- Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын лабораторид химийн урвалж бодис худалдан авахад 6.0 сая төгрөг,
- Хил хамгаалах туслах хүчний зөвлөлд сансрын холбооны антен худалдан авахад 5.0 сая төгрөг,
- Аймгийн Прокурорын газарт тавилга худалдан авахад 8.9 сая төгрөг.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 4.1.24 дэх “Хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ”, 6.6.6 дахь “Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

10.2.5 Замын сан, хөрөнгө оруулалтын барьцааны дансны талаар

-Тайлант онд замын сангийн хөрөнгөөр ажлын нэр төрөл, газар зүйн байрлалын хувьд нэг төрлийн болон ижил цаг хугацаанд тендер зарласан “Аймгийн нэгдсэн эмнэлгээс 1 дүгээр сурууль хүртэлх хайрган хучилттай зам болон зогсоол барих” **79.1** сая төгрөгийн, “Сүхбаатар сумын 4 дүгээр багт хайрган хучилттай зам тавих” **80.0** сая төгрөгийн ажлуудыг нэг багц болгож сонгон шалгаруулалтыг зохион байгуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6-д “Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь хэд хэдэн багцад хувааж тендер шалгаруулалт явуулж болно”, 8.7.1-д “тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох” гэж заасантай нийцэхгүй байна.

-Оны эцэст аймгийн ОНХС-аас 46.7 сая төгрөгийг, ОНХО-ын зардлаас 16.6 сая төгрөгийг, замын сангийн зардлаас 5.9 сая төгрөгийг орон нутгийн хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн боловч ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайланд нийт 69.2 сая төгрөгийг зардлаар тайлагнасан байна.

10.2.6 Орон нутгийн хөгжлийн сангийн талаар

2016 онд Сэлэнгэ аймгийн ОНХС-д оны эхний үлдэгдлээс 92.3 сая төгрөгийн, улсын төсвөөс 4,887.3 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, нийт 4,979.6 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэн, 58 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Үүнээс эх үүсвэр бүрэн төвлөрч, 45.5 хувийг буюу 2,223.6 сая төгрөгийг аймгийн, 54.5 хувийг буюу 2,663.8 сая төгрөгийг сумдад олгохоор хуваарилан баталснаас сумдын ОНХС-ийн санхүүжилт 2 хувиар буюу 41.2 сая төгрөгөөр дутуу олгогдсон байна.

Төвлөрүүлэн захирагчийн түвшинд хийсэн аудитаар ОНХС-тай холбоотой нийт 342.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 199.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 143.0 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмж өгөв. /Алдаа зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт № 10-т үзүүлэв /

Аудитаар иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн, төсөвт өртгийг хувааж тендер зарласан, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, техник хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлээгүй, комиссын актаар төсөл, хөтөлбөрийг хүлээн аваагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон, ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн ажлыг хөрөнгийн орлогоор бүртгээгүй зэрэг алдаа, зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- Сүхбаатар сумын ИТХ-аар баталсан ОНХС-гийн 2016 оны төлөвлөгөөнд Хонгор морьт 1-р багт 25ш, Салхит 3-р багт 11 ш, Бор гүвээ 5-р багт 14 ш, Ган зам 7-р багт 11ш гэрэлтүүлэг хийлгэх ажил нийт 76,4 сая төгрөгийн төсөвт өртгөөр батлагдсан байхад ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа төсөвт өртгийг нь хувааж, 2 гүйцэтгэгчийг шалгаруулсан,
- Зүүнбүрэн сумын ИТХ-ын 2016 оны 08 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар “Хогийн цэг, гэрэлтүүлгийн арчлалт хамгаалалт, ногооны техник тоног төхөөрөмж” гэсэн багцаар 18.8 сая төгрөг баталсан боловч гүйцэтгэлээр “Зүүнбүрэн хаалганы засвар, шинэчлэл”-ийн зардалд 10.0 сая төгрөг, ХАА-н техникийн сэлбэг 1,4 сая төгрөг, бусад 4 төрлийн ажилд 1.1 сая төгрөг зэргээр хэд хэд хувааж гүйцэтгэгчийг шалгаруулсан,
- Орхон сум аймгийн ОНХС-аас эрх шилжүүлсэн 75.0 төгрөгийн төсөвт өртөг бүхий “Наадмын талбай барих ажил”-ын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгохдоо эрх бүхий этгээдэд үнийн санал ирүүлэхийг албан ёсоор мэдэгдээгүй бөгөөд барилгын ажил эрхлэх “Тусгай зөвшөөрөл”-ийн хугацаа дуусч, Барилгын хөгжлийн төвийн тодорхойлолт ирүүлсэн Самосон ХХК-ийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан,
- Иргэдийн санал аваагүй нийт 48.1 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд; Алтанбулаг сум 10.0 сая төгрөгийн, Орхон сум 9.9 сая төгрөгийн, Орхонтуул сум 18.9 сая төгрөгийн, Сант сум 4.6 сая төгрөгийн, Түшиг сум 4.7 сая төгрөг.

- *Ерөө сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 8.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Бугант тосгоны нийтийн орон сууцны цахилгааны засвар", 6.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Гудамжны камер суурилуулах", 5,6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Wi-Fi суурилуулах" зэрэг ажлуудыг комиссын актаар ашиглалтад хүлээн аваагүй байхад үлдээгдэл санхүүжилт 7.0 сая төгрөгийг олгосон,*
- *Хушаат сум ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан 18.8 сая төгрөгийн өртөг бүхий паркалсан хүлэмжийг хөрөнгийн дансанд бүртгэлд тусгаагүй байна.*

Арван нэг: ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдсэн төсөл, сангийн талаар

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд байгаль хамгаалах сангийн 8, сум хөгжүүлэх сангийн 17, аймаг хөгжүүлэх сангийн 1, эрсдэлээс хамгаалах сангийн 1, хог, хаягдлын сангийн 2, Аймаг хөгжүүлэх сан (ЖДҮДС) 1, боловсрол сангийн 1 зэрэг нийт 31 сангийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

11.1 Төсөл, сангуудын санхүүгийн тайланд аудит хийх явцад илэрсэн алдаа, зөрчлийн талаар:

Төвлөрүүлэн захирагчийн түвшинд хийсэн аудитаар төсөл, сангийн данстай холбоотой нийт 267.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 109.6 сая төгрөгийн алдааг залруулж, 104.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 52.8 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмж өгөв. */Алдаа зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт № 11, 12-3-д үзүүлэв /*

Аудитаар, зардлын бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан, сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хүүг дутуу хуримтлуулан тооцсон, гэрээг нотариатаар батлуулалгүйгээр зээл олгосон зэрэг алдаа, зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- *Аймгийн хөгжлийн сангийн эргэж төлөгдөх зээлийн зардлаас аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр хэвлүүлэх болон баяр наадмын зардалд 43.8 сая төгрөг, гадаад томилолтын зардалд 7.7 сая төгрөг зэрэг нийт 51.5 сая төгрөгийн зориулалт бус зардлыг гүйлгэн зарцуулсан боловч гүйцэтгэлийг санхүүгийн тайланд бодитоор тайлагнаагүй,*
- *Сүхбаатар сум хөгжүүлэх сангаас 2016 онд нийт 29 иргэнд зээл олгосноос 11 зээлдэгчийн 104.5 сая төгрөгийн зээлийн гэрээг нотариатаар батлуулалгүйгээр 77.0 сая төгрөгийн зээл олгосон, зээлдэгчийн барьцааны гэрээнд тусгагдсан үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг хувийн хэрэгт хавсаргаагүй,*
- *Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн 2016 оны хүүг дутуу хуримтлуулан бүртгэснээс санхүүгийн тайланд 5 сум 105.6 сая төгрөгийн хүүгийн орлогыг дутуу тусгасан байна.*

Арван хоёр. Аймаг, сумын орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар

Орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,857.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 454.6 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 7.0 сая төгрөгийн зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоон, 672.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 723.0 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмжийг холбогдох байгууллагын удирдлагуудад хүргүүлэв. */Алдаа, зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт № 12-1 т үзүүлэв /*

Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн шатанд сумын ИТХ, ЗТДГ, тосгоны захирагчийн алба, хот тохижуулах газар, сум дундын Ойн ангиуд зэрэг 96 орон нутгийн байгууллага, ОНХС, төрийн сангийн санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулан 17 төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитын дүгнэлтэд нэгтгэж, Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаалаар 4 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлэн, аймгийн төсөвтэй шууд харьцдаг 4 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж тус тус “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн түвшинд Аймаг хөгжүүлэх сан, ОНХС, Байгаль хамгаалах сан, Эрсдэлээс хамгаалах сан, ангилагдаагүй зардал, орон нутгийн хөрөнгө оруулалтын санхүүгийн тайлан, төрийн сангийн санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулан, дүнг ТЕЗ-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнд нэгтгэсэн болно.

Арван гурав. Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих төсвийн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд улсын төсвийн тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг ерөнхий боловсролын сургууль 32, хүүхдийн цэцэрлэг 38, ЭМТ 20, соёлын төв 19, соёлын ордон, дуу бүжгийн чуулга 3, номын сан 2, орон нутгийн музей 1, биеийн тамир спорт хороо 6, хүүхдийн байгууллага 2, ГХБХБГ 1, өрхийн ЭМТ 7 зэрэг нийт 131 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д “Аймаг, Нийслэлийн Засаг дарга Засгийн газрын дараах чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлнэ” гэж заасан. Үүнд:

- *Сургуулийн өмнөх боловсрол*
- *Ерөнхий боловсрол*
- *Соёлын үйлчилгээ*
- *Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ*
- *Газрын харилцаа, кадастр*
- *Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ*
- *Нийтийн биеийн тамир*

Үүний дагуу ЭМС, ХНХС, БХБС, БСШУС-ын батлагдсан төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр 2016 онд нийт 43,171.6 сая төгрөгийн санхүүжилт авах төлөвлөгөөтэйгээс 43,171.6 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна. Өөрийн орлогоос 99.6 сая төгрөгийг төвлөрүүлэхээс 89.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, нийт зардлын гүйцэтгэлээр 42,838.0 сая төгрөгийг захиран зарцуулж, зарлагын гүйцэтгэл 99.0 хувьтай тайлагнагдсан байна.

Улсын төсвийн тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,800.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 974.6 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 44.1 сая төгрөгийн зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоон, 365.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 415.9 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмжийг холбогдох байгууллагын удирдлагуудад хүргүүллээ. /Алдаа, зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт № 12-2 т үзүүлэв /

Аудитаар илэрсэн зөрчил, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжүүдийг холбогдох байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрсөн хариу ирүүлсэн болно.

Тусгай шилжүүлгийн нийт 6 байгууллагын санхүүгийн тайланд Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаалаар итгэл үзүүлж гурвалсан гэрээний дагуу 56 байгууллагын санхүүгийн тайланд “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбар, “Далайван аудит” ХХК-ийн Дархан салбар, “Нью Дийл аудит” ХХК, “Дундманхайдай аудит” ХХК, “ЦЭСБ аудит”, зэрэг ХХК-иуд, 66 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулан, 3

байгууллагын санхүүгийн тайланд аймгийн Аудитын газар аудит хийлээ. Санхүүгийн тайлангийн аудитаар их хэмжээний материаллаг алдаа, зөрчилтэй илэрхийлэгдсэн Мандал сумын өрхийн ЭМТ, “Мөнгөн хараа” дуу бүжгийн чуулга зэрэг 2 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлтийг өгсөн бөгөөд бусад бүх байгууллагуудад Зөрчилгүй санал дүгнэлт өгөгдсөн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэлийг харуулбал;

Хүснэгт- 11

№	“Хязгаарлалттай” дүгнэлт “ авсан байгууллага	“Хязгаарлалттай “ санал дүгнэлтийн шалтгаан
1	“ Мандал сумын өрхийн Эрүүл мэндийн төв”	Анхан баримтын бүрдэл ажил, гүйлгээг бүртгэлд тусгасан нийт 8.0 сая төгрөгийн материаллаг алдаа зөрчил илэрсэн.
2	Мандал сумын “Мөнгөн хараа” чуулга	Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдоогүй ажилтан 1-р гарын үсгийг зурж 38.7 сая төгрөгийн төсөв захиран зарцуулсан, бүтэц, орон тоонд батлагдаагүй орон тоонд ажил хавсруулан гүйцэтгүүлэх шийдвэр гарган 0.7 сая төгрөгийн цалингийн зардал гаргасан, нэг ажлын байрыг 2 ажилтанд хавсруулан гүйцэтгүүлэх шийдвэр гаргаж 1.3 сая төгрөгийн цалинг давхардуулан олгосон зэрэг нийт 41.5 сая төгрөгийн материаллаг алдаа зөрчил илэрсэн.

Арван дөрөв. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд нийт 13 ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь заалтын дагуу Сэлэнгэ аймгийн Аудитын газар нь гурвалсан гэрээний дагуу хувийн аудитын компаниудаар орон нутгийн өмчит 10 аж ахуйн нэгжийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгүүлж, ТЕЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгүүлэв.

“Тариалан эрхлэлтийг дэмжих техник дундын үйлчилгээний төв”, “Мандал хишиг хайрхан”, ОНӨААТҮГ –ууд нь тайлант онд огт үйл ажиллагаа явуулаагүй, “Цагааннуур тохижилт” ОНӨААТҮГ нь татан буугдсан тул санхүүгийн тайланд аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс “ТЭДТДҮТөв” ОНӨААТҮГ –ын үйл ажиллагаа нь бүрэн зогссон боловч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас авах 26.9 сая төгрөгийн авлага , ТЭДСантай үүссэн 1,544.2 сая төгрөгийн өр төлбөрийн холбогдох тооцоог хийгээгүй, авлага, өглөгийг бүрэн барагдуулаагүйгээс татан буулгах тухай шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудаар гаргуулалгүй өнөөг хүрч, ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд дансны үлдэгдлээр нэгтгэгдсэн байна.

Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3,063.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 960.0 сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, 2,103.1 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмж өгөгдсөн байна. Алдаа, зөрчлийн *дэлгэрэнгүйг хавсралт № 12-4 т үзүүлэв /*

Аудитаар илэрсэн зөвлөмжүүдийг холбогдох аж ахуйн нэгжийн удирдлагууд хүлээн зөвшөөрсөн болно.

Аудитад хамрагдсан орон нутгийн өмчит 10 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөгдсөн байна.

Арван тав: Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 4,489.0 сая төгрөгийн залруулагдах боломжгүй алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнээс 51.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,143.0 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, 3,294.9 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмж хүргүүлсэн байна.

Арван зургаа. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

- **Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар анхаарал татахуйц дараах асуудал ажиглагдлаа. Үүнд:**
- *Аймгийн хэмжээнд 2016 оны жилийн эцсийн байдлаар 2011-2015 оны хооронд Сум хөгжүүлэх сангаас иргэн, аж ахуйн нэгжид олгосон зээлийн хугацаа хэтрэлт 2,872.1 сая төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 1,105.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. / Судалгааг хавсралт № 14 -т үзүүлэв /*
- *Аймаг хөгжүүлэх сангаас / ЖДҮ-ийг дэмжих сан/ 2009-2015 оны хооронд олгосон зээлийн хугацаа хэтрэлт 4,008.9 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 1,021.4 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд 2016 онд аймгийн Аудитын газраас хийсэн “Аймаг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс зээлийн хугацаа хэтрэлт нэмэгдсээр байна./ Судалгааг хавсралт № 15 -д үзүүлэв /*
- *Байгууллагын хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцаж байгаа албан тушаалтанд олгох нэмэгдэл, урамшууллын хэмжээг УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 3.1 дэх “Нийтийн албаны удирдлага нь... албан тушаалынх нь цалингийн 40 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл урамшуулал олгох...” гэж заасан байдаг. Аудитын явцад хийсэн судалгаанаас харахад сумын ЗДТГ-ын бүтцэд ХАСХОМ мэдүүлэх үүрэг бүхий 5-15 төрийн албан хаагч байдаг бөгөөд ЭБАТ / эрх бүхий албан тушаалтан / -ны цалингийн нэмэгдлийг сар бүр үндсэн цалингийн 20,0-40,0 хувиар, аймгийн ЗДТГ-Т 10,0 хувиар тус тус тогтоон, харилцан адилгүй олгож байна. Иймээс аймгийн ТЕЗ-ийн зүгээс уг нэмэгдлийн хувь, хэмжээг нэгдсэн журмаар тогтоон мөрдүүлэх нь зүйтэй юм. /Судалгааг хавсралт №16-д үзүүлэв /*
- *Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолоор сумдад үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагуудад санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ хүргэх, сумын төсөв, санхүү, эдийн засаг, хөгжлийн бодлогын төлөвлөлтийг хариуцсан Санхүүгийн албыг байгуулахаар шийдвэрлэснээр 17 суманд Санхүүгийн алба байгуулагдсан байна. Аудитын явцад сумдын Санхүүгийн албадын орон тоо, хариуцаж байгаа байгууллага, цалин тогтоолт, олголтын талаар судалгааг гаргахад Засгийн газрын 2015 оны 426 дугаар тогтоолоор оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу Сүхбаатар, Мандал сумын төсөвт байгууллагын нягтлан бодогч нар Санхүүгийн албанд харьяалагдахгүйгээр зохицуулагдсан байна. Судалгаагаар сумдын нэг нягтлан бодогчийн хариуцаж байгаа байгууллагын тоо харилцан адилгүй байгаа бөгөөд ихэнх сумдын Санхүүгийн албаны нягтлан бодогчид сумын ЗДТГ-ын үндсэн ажилтнаар цалинжиж байгаа бол Алтанбулаг, Сайхан зэрэг сумдын Санхүүгийн албаны нягтлан бодогчид хариуцаж буй байгууллага тус бүрээс ажил хавсран ажилласны нэмэгдэл, эмнэлэг, сургууль, цэцэрлэгээс улирлын үр дүнгийн урамшуулал авч байна. Санхүүгийн албаны харьяалалд ороогүй Сүхбаатар,*

Мандал сумдын нягтлан бодогч нар нь хариуцсан байгууллагын тооноос үл хамааран боловсрол, Эрүүл мэндийн байгууллагаас олгодог улирлын урамшуулалд тогтмол хамрагдах эрх нь нээлттэй байдаг бол бусад сумдын Санхүүгийн албаны нягтлан бодогчдын хувьд хууль эрх зүйн хувьд хязгаарлагдмал байна. Иймд сумдын Санхүүгийн албаны бүтэц, зохион байгуулалт, ажлын байрны тодорхойлолт, цалин хөлс олголтыг нэгдсэн бодлогоор зохицуулж, хяналт тавьж ажиллах нь зүйтэй байна. /Судалгааг хавсралт №17-д үзүүлэв./

- 2016 онд үйл ажиллагаа явуулж, аймгийн ТЕЗ-ийн жилийн эцсийн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн орон нутгийн өмчит 10 аж ахуйн нэгжээс 7 нь үйлдвэрлэлийн үр дүнгээр 13,7-1,145.4 сая төгрөгийн хооронд нийт 1,498.9 сая төгрөгийн алдагдал хүлээсэн бөгөөд 9 нь 0,5-1,219.8 сая төгрөгийн хооронд нийт 3,374.3 сая төгрөгийн авлага, 10 нь 1,3-1,311.5 сая төгрөгийн хооронд нийт 6,325.0 сая төгрөгийн өр төлбөртэй тайлагнагдсан байна. Эдгээрээс дулаан үйлдвэрлэх, дулааны эрчим хүчээр хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ-ын алдагдал, авлага, өр төлбөр жил ирэх бүр нэмэгдэж алдагдал 1,145.4 сая төгрөг, авлага 680,9 сая төгрөг, өглөг 3,945.9 сая төгрөгт хүрсэн, цэвэр усаар хангах, бохирыг татан зайлуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Гавшгай-Ус компанийн авлага 1,219,8 сая төгрөг, өглөг 1,202.4 сая төгрөгт хүрсэн, Урсгал-Ус компанийн авлага 1,142,4 сая төгрөг, өглөг 782.3 сая төгрөгт хүрсэн байгаа нь хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцлийг улам бүр алдагдуулж байна. /судалгааг хавсралт 18-д үзүүлэв / Цаашид аймгийн Аудитын газраас 2016 онд хийж гүйцэтгэсэн “Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитуудаар өгөгдсөн зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлж, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг хэвийн явуулах арга хэмжээ авах шаардлагатай байна.
- Жил бүр аймгийн ТЕЗ-ийн жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудитаар тус тайланд нэгтгэгдэж буй байгууллагуудын бүртгэлийн үйл ажиллагаанд оршиж буй ихээхэн хэмжээний алдаа, зөрчлийг илрүүлж, залруулах боломжтойг нь залруулан, боломжгүйг нь дараагийн санхүүгийн тайланд давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөгдөж ирсэн боловч Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС болон Сангийн сайдын тушаалаар баталсан журмуудыг зөрчсөн алдаа, зөрчил давтагдан гарсаар байна. Иймээс цаашид баьгууллагуудын бүртгэлийн ажилтнуудын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх замаар аудитаар өгөгдсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн, бүртгэлийн үйл ажиллагаанд холбогдох хууль, стандарт, дүрэм, журмыг мөрдөн ажиллах шаардлагатай байна.

Арван долоо. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар тус тайланд нэгтгэгдсэн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой гүйцээж, мөшгин шалгаж амжаагүй, дараагийн аудитуудаар нягталж шалгах асуудал гараагүй бөгөөд ОНХС, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд тусгайлан нийцлийн болон гүйцэтгэлийн аудитууд хийгдэж байна.

Цаашид эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн зээлийн их хэмжээний үлдэгдэлтэй тайлагнагдсан “Аймаг хөгжүүлэх сан”, “Сум хөгжүүлэх сан”, их хэмжээний өр, авлагатай тайлагнагдсан, үйлдвэрлэлийн үр дүнгээр олон жил дараалан алдагдал хүлээсэн орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд болон өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагаа, эргэлтийн эмийн сангийн зохион байгуулалтын өөрчлөлтөд аудит хийх шаардлагатай гэж үзэж байна.

Арван найм. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 6,381.5 сая төгрөгийн материаллаг бус, 606.4 сая төгрөгийн материаллаг зэрэг нийт 6,987.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2,498.8 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 51.1 сая төгрөгийн зөрчлийг холбогдох байгууллага, хувь хүмүүсээр төлүүлэх төлбөрийн акт тогтоон, 1,143.0 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах албан шаардлага, 3,294.9 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгуулах, цаашид давтан гаргахгүй байх талаар аудитын зөвлөмж өгөв. */Алдаа, зөрчлийн нэгтгэлийг хавсралт № 12, 13-т үзүүлэв./*

Арван ес. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

ТЕЗ-ийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 14 зөвлөмж өгснөөс тайлант хугацаанд 9 зөвлөмжийг хэрэгжүүлж, 5 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс алдаа, зөрчлүүдийг давтан гаргасан байна. Үүнд:

- *Орон нутгийн байгууллагуудын санхүүгийн тайланд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийн эзэмшил байгууллагын нэр дээр улсын бүртгэлд бүртгэгдсэн эсэхийг баталгаажуулж, ашиглалтад хяналт тавьж ажиллах,*
- *Орон нутгийн төсвийн болон төсөвт байгууллагын өөрийн орлогыг бодитой төлөвлөж, төлөвлөгөөг бүрэн биелүүлж ажиллах,*
- *Засаг даргын нөөц хөрөнгийг журамд зааснаас бусад арга хэмжээнд зарцуулах зөрчлийг таслан зогсоох,*
- *Хөрөнгө оруулалтын арга хэмжээг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу хэрэгжүүлэх,*
- *Төсөвт байгууллагуудын цалингийн зардлын гүйцэтгэлд тавих төрийн сангийн хяналтыг сайжруулах, төсөвт зохицуулалт хийгдээгүй байхад зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулдаг зөрчлийг арилгуулах,*

Хорь. Аудитын зөвлөмж.

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 10 зөвлөмжийг Менежментийн захидлаар хүргүүлэв.

Хорин нэг. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Санхүүгийн тайлангийн аудитын гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 81,396.2 сая төгрөгийн 1 хувиар тооцож 814.0 сая төгрөгөөр тогтоосон бөгөөд аудитаар 606.4 сая төгрөгийн материаллаг зөрчил илэрсэн нь материаллаг байдлын түвшингээс бага байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна. Аудитын тайланд нийт хуудас материалыг хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН: ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БАТМӨНХ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

С.БАТ-ЭРДЭНЭ

2017.04.18